

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН
ОХУ-ЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ДОРНО ДАХИНЫ ГАР БИЧМЭЛИЙН ХҮРЭЭЛЭН
ОЛОН УЛСЫН МОНГОЛ СУДЛАЛЫН ХОЛБОО**

ХУРЛЫН ЗАР.



Монгол улсын Ерөнхийлөгчийн дэмжлэгтэйгээр

**“МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ:
ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА”**

зургаадугаар удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурал
2023 оны 4 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд зохиогдоно.

Зохион байгуулагчид: Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн
ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн
Олон улсын Монгол судлалын холбоо

Хамтран оролцогчид: “Чингис хаан” үндэсний музей
Монгол улсын Үндэсний Төв архив
Монгол улсын Үндэсний Номын сан
Монгол Улсын Их сургууль
Монгол улсын ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэн
ОХУ-ын “Улсын Эрмитаж” музей
ОХУ-ын Санкт-Петербургийн Улсын Их сургууль

Зохион байгуулагдах газар: Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн
(Монгол улс, Улаанбаатар хот)

Эрдэм шинжилгээний хурлын зорилго: Монгол улс, ОХУ, БНХАУ, Япон болон өрнөдийн улс орнуудад хадгалагдаж буй монголын ард түмний оюун санаа, соёлын баялаг өв болох гар бичмэл ба архивын хосгүй дурсгалуудын талаар мэдээлэл солилцох, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, тэдгээрийг судлах, хэвлэн нийтлэх орчин үеийн хандлага, арга зүйг тодорхойлох, хамтран ажиллах боломжийг өргөжүүлэхэд оршино.

Хуралд оролцох эрдэмтэн судлаачид Та бүхэнд дараах сэдэв, чиглэлийг санал болгож байна. Үүнд:

- Монголын бичгийн дурсгалуудын судалгаа;
- Монголын түүхийн сурвалж бичгүүд, судалгааны шинэ хандлага;
- Монгол ба Орос: соёл хоорондын яриа хэлэлцээний онцлог;
- Түүхийн янз бүрийн үе дэх удирдлагын тогтолцооны бүтэц;
- Монголчуудын засаглалын бүтэц ба төр улсын үүслийн онцлог;
- Монголчуудын аман зохиол, утга зохиол ба хэл: өнгөрсөн ба өнөө үе;
- Монголын соёл дахь шашны уламжлал

Хурлын хэл: монгол, орос, англи

Хуралд оролцох тухай мэдүүлгийг 2023 оны 1 дүгээр сарын 31-нээс өмнө Зохион байгуулах хорооны нарийн бичгийн дарга нарт дараах хаягаар илгээнэ. Үүнд:

Ц.Энхчимэг (enkhchimeg@mas.ac.mn),
Н.Хишигт (n.khishigt09@gmail.com),
И.В.Кульганек (kulgan@inbox.ru),
Д.А.Носов, эл. адрес: (dnosov@mail.ru)

Мэдүүлэгт: Оролцогчийн овог нэр, эрдмийн зэрэг цол, ажлын газар, цахим хаяг, утасны дугаар, илтгэлийн нэрийг бичнэ.

Хурлын өмнө илтгэлүүдийн хураангуйг хэвлэх тул 2023 оны 2 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү. (Хэмжээ: 800 хүртэл үгтэй). Илтгэлүүдийн бүрэн эмхэтгэл хурлын дараа хэвлэгдэнэ.

Зохион байгуулах хорооны дарга:

Олон улсын Монгол судлалын холбооны
Ерөнхий нарийн бичгийн дарга, академич **С.ЧУЛУУН**
Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал,
түүхийн ухааны доктор **Ц.ЦЭРЭНДОРЖ**
Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн захирал, түүхийн шинжлэх
ухааны доктор, Оросын ШУА-ийн сурвалжлагч гишүүн **И.Ф.ПОПОВА**

Зохион байгуулах хорооны нарийн бичгийн дарга:

Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), проф. **Ц.ЭНХЧИМЭГ**
Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), проф. **Н.ХИШИГТ**
ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн секторын
эрхлэгч, хэл бичгийн ухааны доктор **И.В.КУЛЬГАНЕК**
ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ахлах ажилтан, хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн **Д.А.НОСОВ**

Оролцогчдод зориулсан мэдээлэл:

2023.04.18. – Хуралд оролцогч гадаадын эрдэмтдийг хүлээн авах, байрлуулах
2023.04.19-20. – Эрдэм шинжилгээний хурал
2023.04.20. – Соёлын арга хэмжээ
2023.04.21 – Хурлын төлөөлөгчид буцах